

“ЖҮЧЭ” ГҮН УХААНЫ ОНЦЛОГ

Ж.Каламхас - Дархан-Уул аймаг, Техникийн Дээд Сургуулийн багш, магистр

Түлхүүр үг: Чуче-эзэн, би, хүн, эх оронч үзэл, үндэсний чанар.

Оршил. Өнөө үед манай иргэдийн үзэл санаанд үндэсний үзэл, эх оронч үзэл, үндэсний сэтгэлгээ гэх ойлголтууд бүдгэрч байгаа нь хэн хүний анхаарлыг татсан асуудлын нэг болоод байна. Иймээс иргэдэд эх оронч үзэл, үндэсний сэтгэлгээг бий болгох талаар төрөөс тодорхой бодлого боловсруулж, энэ чиглэлээр олон талт арга хэмжээ авах нь зүйтэй бөгөөд тийм арга хэмжээний нэг бол ийм асуудлаархи гадаад орны гүн ухааны онол сургаалуудыг судлан, тэднээс суралцах явдал юм. Тэдгээр онол сургаалуудын нэг болох солонгосын “Жүчэ” гүн ухааны үзэл агуулгыг энэхүү өгүүлэлдээ авч үзэхийг зорилоо. Энэхүү сэдвийн хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн тавилаа. Үүнд:

- “Жүчэ” гүн ухааны тухай ерөнхий ойлголтыг авч үзэх
- “Жүчэ” гүн ухааны өвөрмөц агуулга, үндсэн зарчмыг тайлбарлах эдгээр болно.

“Жүчэ” гүн ухааны тухай ерөнхий ойлголт. 1920-оод оны үед Б.Н.А.С.А.У-ын удирдагч Ким Ир Сен нь Жүчэ гүн ухааны онол, үзэл санааг үндэслэсэн байна. Ким Ир Сен түүхэнд анх удаа Жүчэгийн болон үндэсний чанарыг хамгаалах тухай үзэл санааг дэвшүүлэн, түүнийгээ амьдралд хэрэгжүүлсэн бөгөөд хувьсгал ба бүтээн байгуулалтыг ялалтаар удирдсан аугаа их үзэл суртлын онолч улс төрч хэмээн солонгосчууд үздэг юм. Тэрээр өөрийн гүн ухааны сургаалдаа эх оронч сэтгэлгээ, үндэсний чанар, хүн төвт, бие даасан үзлийн тухай ойлголтыг онцлон авч үзсэн байдаг.

Энэхүү өгүүлэлд Ким Ир Сений гүн ухааны үзлийг тууштай үргэлжлүүлсэн хүний нэг болох Ким Чен Ирийн үзэл баримтлалыг үндэслэн Жүчэ гүн ухааны талаар авч үзлээ. Тухайлбал, Ким Чен Ирийн үзлээр, “Жүчэгийн гүн ухаан нь ертөнц ба хүний хоорондын харилцааны асуудал, ертөнцөд хүний эзэлж буй байр суурь, үүргийн асуудлыг гүн ухааныхаа үндсэн асуудал болгон шинээр дэвшүүлж, хүн бол бүхний эзэн, бүхнийг шийдвэрлэнэ гэсэн гүн ухааны зарчмыг дэвшүүлсний үндсэн дээр хүний хувь заяаг нээх хамгийн зөв замыг тодорхойлсон юм”³¹.

Ертөнцийг үзэх хүн төвтэй үзэл болох жүчэгийн гүн ухааны үзэл санаа бол ард түмнийг хайрлах нандин үзэл санаа болохын зэрэгцээ улс орон, үндэстнээ хайрлах үзлийн нэг бөгөөд энэхүү үзэлд дэлхийн бие даасан үйл хэргийг эрчимтэй урагшлуулж явах замыг тодорхойлсон байна. Энэхүү гүн ухаанд ертөнцийн төв болох хүнийг нийгэм, оюун санаа талаас нь голчлон авч үзэн тайлбарлажээ. Нийгмийн хөгжил, хөдөлгөөн, харилцаанд хүн оршиж амьдарч байдаг. Иймээс хүн нийгмийн хөдөлгөгч хүч бөгөөд бүх юмны эх үндэс, эзэн нь юм.

Улс үндэстний хувь заяа бол хувь хүний тавилан мөн бөгөөд үндэстний амьдралын дотор хувь хүний амьдрал байна гэдгийг уг онцлон илэрхийлсэн буй.

³¹ Ким Чен Ир. Жүчэгийн гүн ухаан бол хувьсгалын өвөрмөц гүн ухаан мөн. УБ., 2005, 4 дэх тал

Энэ гүн ухааны “Үндэсний чанар” гэдэг ойлголт нь үндэстнийхээ өөрийн гэсэн шилдэг онцлогийг хадгалан уламжлан хөгжүүлж, түүнийг нийгмийн амьдралын бүх салбарт хэрэгжүүлэхийг илэрхийлдэг байна. Түүнчлэн үндэсний шилдэг чанарыг хөгжүүлэн алдаршуулах чухал зүйл бол үндэсний өвийг зөв залгамжлан хөгжүүлэх явдал мөн гэж тодорхойлсон байдаг.

“Жүчэ” гүн ухааны үзлээр, “Бүх улс орон үндэстэн тэгш эрхтэй, бие даасан байдалтай юм. Улс орон ба үндэстэн бол хүмүүсийн амьдралын үндэс ба хувь заяаг нээх гол нэгж бөгөөд ард олны хувь заяа улс орон, үндэстний хувь заяатай салшгүй холбоотой юм. Улс орон, үндэстний бие даасан чанар хангагдаагүй нөхцөлд ард олны бие даасан байдал хэрэгжиж чадахгүй”.

Мөн энэхүү гүн ухаанд “Жүчэгийн болон үндэсний чанар дарагдаж, улс орон ба үндэсний бие даасан байдал гишгэгдэх юм бол улс орнуудын болон үндэстнүүдийн хооронд тэгш бус байдал, зөрчил бий болж, нэгдэл нягтрал, хамтын ажиллагаа хэрэгжиж чадахгүй” хэмээн тэмдэглэсэн байдаг. Бие даан хөгжих нийгэм-эдийн засгийн бэрхшээл, үндэсний мөргөлдөөний гай зовлонг туулж байгаа орнууд ч түүнийг даван туулах аргыг өөрөө олох хэрэгтэй, бусдыг буруутгаж болохгүй. Дэлхийн дэвшилтэт ард түмэнтэй эв нэгдэл, хамтын ажиллагааг бэхжүүлэн, нийгмийг ардчилах тэмцлийг идэвхтэй өрнүүлснээр бүх улс үндэстний бие даасан байдлыг хамгаалж, дэлхийг бие даасан болгох тэмцэлд бид өөрсдийн үүргийг гүйцэтгэх хэрэгтэй хэмээн хувь хүн, ард түмэндээ хандан уриалсан буй.

“Жүчэ” гүн ухаан нь нийгмийн зүй зохистой хөгжлийн дээд шат бол зөвхөн социализм гэж үздэг. Учир нь улс орон, үндэсний жинхэнэ хөгжил дэвшил нь зөвхөн үндэстний гишүүд нийтлэг сонирхолтой болж, нийгмийн бүх баялаг үндэсний нийтийн хөгжилд ашиглагдах социалист нийгэмд л хэрэгжинэ. Социализм бол үндэсний чөлөөт хөгжлийг хангаж, ангийн мөлжлөг болон үндэсний бүх тэгш бус байдлыг арилгана. Социализмын сонгодог жишээг хөгжүүлэх нь ард түмний оролцоо, ялангуяа тэдний эх орныхоо төлөө тэмүүлэх чин эрмэлзэл чухал үүрэгтэй гэж бичсэн байна. Эх оронч сэтгэлгээг хүн бүрт бий болгон төлөвшүүлэхэд уран зохиолын төрөл зүйл, олон ангит уран сайхны кино урлаг болон боловсролын системд тусгах ёстой гэдгийг жүчэгийн гүн ухааны онолд чухалчлан дурдаж өгсөн байна.

Жүчэ гүн ухааны өвөрмөц агуулга, үндсэн зарчим. Ким-Ир-Сений дэвшүүлсэн үзэл санааг кимирсенизм гэж нэрлэдэг бөгөөд энэ бол жүчэгийн гүн ухааны үзэл санаа, онол, аргын тогтолцоо гэж үздэг байна. Энэхүү гүн ухааны гол агуулга нь хүн байгалийг өөрчилж, материаллаг баялгийг бүтээж, өөрийн материаллаг нөхцлийг хангана. Байгалийг өөрчилж, материаллаг баялгийг бүтээх ажил бол хүмүүсийн нийгмийн хэрэгцээг хангах ажил хэрэг бөгөөд тэр нь хүмүүсийн нийгмийн хамтын ажиллагаагаар л хэрэгжих боломжтой. Нийгмийн хөдөлгөөн бол ертөнцийг захиран өөрчилж буй хүний хөдөлгөөн мөн. Нийгмийн хөдөлгөөнд урсгалт чанар үйлчилж байгаа нь хүний бие даасан, бүтээлч, ухамсартай хөгжлийн түвшин харьцангуй доогуур байгаа, мөн түүнийг хангалттай хөгжүүлж чадах нийгмийн байгуулал тогтоогүй байгаатай холбоотой³² хэмээн үздэг. Хүн байгалийг ч, нийгмийг ч өөрчилж байна. Хүн нь байгаль, нийгмийг өөрчлөх үйл ажиллагааг явуулахдаа өөрөө өөрийгөө тасралтгүй өөрчлөн хөгжүүлж байдаг. Ертөнцийг захиран өөрчлөх хүний үйл ажиллагаа нь эцсийн дүндээ байгаль, нийгэм, хүнийг өөрчлөх ажлын явцад хэрэгжих бөгөөд түүний жүчэ бол ард түмэн мөн.

Тэрээр, “Хувьсгалт үзэл санааг манай эрин цагийн марксизм-ленинизм” хэмээн нэрлэж байсан билээ. Мэдээж хэрэг, энэ томъёололд өөрийн чанар

³² Ким Чен Ир. Жүчэгийн гүн ухаан бол хувьсгалын өвөрмөц гүн ухаан мөн. УБ., 2005, 10 дахь

байгаа боловч энд марксизм-ленинизмийн хүрээн дотор залгамж чанартай байгаа тухай онцолсон байгаа учир энэ тодорхойлолт оновчтой бус юм. Өнөө үед ч Жүчэгийн үзэл санааг марксизм-ленинизмд тааруулан тайлбарлаж буй хандлага нэлээд байдаг. Жүчэгийн үзэл санаа, онол, аргын тогтолцоог кимирсенизм гэж тодорхойлсон нь түүний агуулгад жүчэгийн үзэл санаа гол болсон ба түүний бүрэлдэхүүн хэсэг нь үзэл санаа, онол, аргын тогтолцоо болж байгааг илэрхийлж байгаа болно.

Кимирсенизм бол өөрийн агуулгын болон бүрэлдэхүүн хэсгийн хувьд ч марксизм-ленинизмын хүрээнд тайлбарлах боломжгүй өвөрмөц бие даасан сургаал мөн. Кимирсенизмын гол цөм болсон жүчэгийн үзэл санаа бол хүн төрөлхтөний сэтгэлгээний түүхэнд гарсан шинэ нээлтийн нэг гэж зүй ёсоор үзэх боломжтой. Жүчэгийн үзэл санааг марксист материалист диалектик үүднээс тайлбарлах оролдлого байдаг. Тухайлбал жүчэгийн гүн ухааны үзэл санааг “жүчэгийн материализм”, “жүчэгийн диалектик” хэмээн нэрлэж байна. Энэ бол жүчэгийн үзэл санааны онцлогийн талаар зөв ойлголтгүй байгаагийн илэрхийлэл мөн хэмээн Ким Чен Ир олонтоо шүүмжилсэн буй.

Марксизм ба кимирсенизмийн үзэл зарчмын хувьд их ялгаатай өөр өөр үзэл болохыг тэрээр дараах байдлаар тайлбарласан байна. Марксизмийн материалист диалектикт матери ба ухамсар, ахуй ба сэтгэхүйн харьцааны асуудлыг гүн ухааны үндсэн асуудал болгон дэвшүүлж, материйн анхдагч чанар, ахуйн анхдагч чанарыг нотолсны үндсэн дээр объектив ертөнцийн хөдөлгөөний хуулийг тогтоосон юм. Харин жүчэгийн гүн ухааны үзэл санаа бол ертөнцийн материаллаг чанар ба түүний хөдөлгөөний ерөнхий хуулиудыг тодруулсан нөхцөлд ертөнцөд хүний эзлэх байр суурь, үүргийн тухай асуудлыг гүн ухааны үндсэн асуудал болгон шинээр дэвшүүлж, **хүн бол бүхний эзэн бөгөөд бүхнийг шийдвэрлэнэ** гэсэн үндэслэлийг нотолж, үүний үндсэн дээр хүн ертөнцийг эзэгнэх, өөрчлөн хувиргах тухай зүй тогтолыг илрүүлсэн өвөрмөц үзэл болно.

Тухайлбал, “Жүчэгийн үзэл санаанд хүнийг ертөнцийн зөвхөн нэг хэсгийн хувьд биш, харин ертөнцийг удирдан залуурдах эзэгнэгч хүч гэж үздэг юм.” Мэдээж, жүчэгийн үзэл санааны энэхүү гүн ухааны зарчмыг материалист диалектикийн хүрээнд тайлбарлах боломжгүй юм. Жүчэгийн үзэл санааг өмнөх онолын тогтолцоо, агуулгад тааруулж тайлбарлах гэсэн хандлага нь нийгэм-түүхийг үзэх үзэлд илүү харагдаж байна.

Солонгосын гүн ухааны нэлээд сурах бичгүүдийг сөхөн үзвэл, жүчэгийн гүн ухааны үзэл санааны тодорхойлсон нийгэм-түүхийн зарчмыг марксист түүхийг үзэх материалист үзэлд хүчээр тааруулан тайлбарлаж байгаа хандлагыг олж харж болно.

Марксист түүхийг үзэх материалист үзэл нь материаллаг ертөнцийн ерөнхий хуулийг нийгэм түүхэнд хэрэглэсэн жишээ юм. Мэдээж нийгэм ч материаллаг ертөнцөд хамаарах тул материаллаг ертөнцийн ерөнхий хуулиуд энд үйлчилэх нь зүй ёс юм. Гэвч нийгэмд байгалиас ялгаатай өөрийн гэсэн хөдөлгөөний хууль үйлчилж байдаг. Байгалийн хөдөлгөөнд субъект үгүй, харин нийгэм-түүхийн хөдөлгөөнд субъект байхын зэрэгцээ нийгэм –түүхийн хөдөлгөөн нь субьектийн нөлөө ба үүргээс гадна байх үндэсгүй юм. Жүчэгийн үзэл санаанд субьектийн хөдөлгөөн болох нийгэм-түүхийн хөдөлгөөний зүй тогтолыг илрүүлсэн юм.

Жүчэгийн үзэл санааны тодорхойлсон нийгэм-түүхийг үзэх үзэл нь нийгэм түүхийн хөдөлгөөний онцгой зүй тогтолыг үндсэн агуулгаа болгож байдаг. Иймд энэхүү нийгэм-түүхийг үзэх Жүчэгийн үзэл онолыг түүхийг үзэх материалист үзэлд хүчээр тааруулж тайлбарлах бололцоогүй. Жүчэгийн үзэл санаа бол гүн ухааны шинэ зарчим, нийгэм-түүхийн зарчмыг тодорхойлж байгаагийн зэрэгцээ

хувьсгал ба бүтээн байгуулалтын тэргүүлэх зарчмыг ч тодорхойлж буй өвөрмөц үзэл санаа мөн болохыг тэрээр олонтоо учирлан өгүүлсэн байна.

Ажилчин ангийн хувьсгалын онолын хөгжлийн үүднээс үзвэл марксизм-ленинизм нь кимирсенизмийн өмнөх түүхэн үеийн хувьсгалын онол мөн билээ. К.Маркс материалист диалектикт үндэслэн капитализм мөхөж, социализмд шилжих нь зайлшгүй гэдгийг шинжлэх ухааны үүднээс нотолсон бол, В.И.Ленин түүний сургаалийг залгамжлан монополист капитализмыг судалсны үндсэн дээр капитализмийн тэгш бус хөгжлийн хууль болон тодорхой нэг оронд социализм ялж болох тухай тодорхойлж, социалист байгууллыг тогтооход чиглэсэн хувьсгалын онолыг дэвшүүлсэн билээ. Ийм учир марксизм-ленинизмийн хувьсгалын онол өөрийн үндсэн агуулгад капитализм, империализмийг түлхэн унагаж, социалист байгууллыг тогтоох тухай онолыг багтааж байна.

Харин Кимирсенизмийн хувьсгалын онол бол марксизм-ленинизмийн төрсөн цаг үеэс ялгаатай, шинэ эрин цагийн хувьсгалт практикийн тавьсан асуудалд хариулт өгсөн өөрийн онцлогтой хувьсгалын онол хэмээн Ким Чен Ир дүгнэжээ. Ким-Ир-Сен нь Жүчэгийн гүн ухааны гол үзэл санаа болсон манай эрин үеийн үндэсний болон ангийн, хүний эрх чөлөөны онол, стратеги ба тактикийг гүнзгий тодруулж өгсөн юм. Ийм учир кимирсенизмийн хувьсгалт онол бол Жүчэгийн эрин үеийн коммунист хувьсгалын төгс онол гэж тэд үздэг байна. Энэ талаар Кимирсенизм нь социализм, коммунизмыг байгуулах асуудлыг шинээр нээн тодорхойлсон гэж БНАСАУ-ын философичид ойлгодог ажээ.

Мэдээж марксизм-ленинизмийг үндэслэгчид ч социалист, коммунист нийгмийн тухай хэд хэдэн үзэл баримтлал дэвшүүлсэн боловч тэдгээр нь урьдчилсан таамаг төдийхнөөс хэтэрч чадаагүй байсан хэмээн тэд бас шүүмжилсэн буй. Ажилчин ангийн хувьсгалт онолд кимирсенизм нь удирдлагын аргын тухай асуудлыг шинээр дэвшүүлэн тавьж, түүнийг бүх талаар нь тодруулсан гэж үздэг байна. Удирдлагын тухай асуудал бол ажилчин ангийн хувьсгалт тэмцэлд онолын ба практикийн хувьд бие даасан ач холбогдолтой асуудал мөн.

Ажилчин ангийн хувьсгалын үйл хэрэг, социализм ба коммунизмын үйл хэрэг бол ертөнцийг үндсээр нь өөрчлөн хувиргах нэн чухал, хүнд бэрх тэмцэл мөн бөгөөд өргөн ард олны оролцостой их цар хүрээтэй тэмцэл юм. Иймээс зөв удирдах тэргүүлэх онолын зэрэгцээ удирдлагын зөв арга баталгаажсан нөхцөлд энэхүү үйл хэрэг ялалтаар төгсөх болно.

Удирдлагын аргын асуудал бол ажилчин ангийн нам засгийн эрхийг авснаар шинэ нийгмийг удирдах, социалист ба коммунист байгуулалтыг удирдахад улам чухал болж байдаг ажээ. Харин одоо хүртэл ажилчин ангийн хувьсгалт онолд удирдлагын аргын асуудлыг бие даасан тогтолцоот онол болгон дэвшүүлж чадаагүй юм. Удирдлагын аргын тухай онолыг шинээр тодруулж, бие даасан бүрэлдэхүүн хэсэг болгон тогтолцоотой болгосон нь кимирсенизмийн гавьяа мөн хэмээн үздэг байна.

Кимирсенизм бол удирдлагын аргын тухай асуудлыг хувьсгалд ялалт байгуулах үндсэн асуудлын нэг болгон дэвшүүлж, бүх талаас нь тодруулсан бөгөөд ялангуяа эрх баригч намын удирдлагын арга болон социалист, коммунист байгуулалтыг удирдах аргыг шинээр тодруулж боловсруулсан юм. Гэтэл одоо зарим тохиолдолд кимирсенизмийн бие даасан бүрэлдэхүүн хэсэг болох удирдлагын аргын асуудлыг ямар нэгэн арга зүйн асуудал мэтээр буруу тайлбарлаж байна. Энэ нь кимирсенизмийн удирдлагын онолын агуулга, түүний өвөрмөц онцлогийн талаар зөв ойлголтгүй байгаагийн илэрхийлэл юм. Дээр өгүүлснээр кимирсенизм бол бүтцийн тогтолцоо, агуулгын хувьд марксизм-ленинизмээс ялгаатай, бие даасан гүн ухаан гэж Ким Чен Ир дүгнэжээ.

Ард түмэн түүхэнд анх удаагаа ертөнцийг эзэгнэгч болж, өөрийн хувь заяаг бие даан бүтээлчээр нээж явах хүн төрөлхтний түүхийн шинэ эрин үе, мөн ажилчин ангийн хувьсгалт хөдөлгөөн хол алхаж, дэлхий даяар өргөн гүнзгий өрнөж байгаа манай эрин үеийн хувьсгалт практик нь хувьсгалын шинэ тэргүүлэгч үзэл, онолыг шаардах болж өргөн ард олныг хувьсгалд зохион байгуулж нягтруулах тухай удирдлагын асуудлыг хувьсгалын хувь заяатай холбоотой нэн чухал асуудал болгон дэвшүүлэн гаргасан онол бол Жүчэ онол хэмээн үзэж, түүнийгээ хүчтэй сурталчилдаг ажээ.

Жүчэгийн үзэл санаагаар тодруулсан хувьсгалын онол, аргыг гурван бүрэлдэхүүн хэсэг болгож буй кимирсенизм нь хувьсгалт хөдөлгөөний хөгжлийн энэхүү шинэ шаардлагад хариулт өгсөн хэмээн энэ онолын ач холбогдлыг өндрөөр үнэлдэг байна.

Кимирсенизм бол Жүчэгийн үзэл санааг гол цөм болгосон үзэл суртал- онолын тогтолцоо юм. Түүний өвөрмөц чанар нь Жүчэгийн өвөрмөц чанараар тодорхойлогдож байна. Энэ онолын нэг гол баримтлал нь Ким Чен Ирийн хэлснээр: "Нийгмийн хөгжил нь ард түмний бие даасан, бүтээлч, ухамсарт чанарын хөгжлийн явц бөгөөд ард олны бие даасан, бүтээлч ухамсар дээшилж, түүний шаардлагын дагуу нийгмийн байгуулал боловсронгуй болбол нийгэм өрнөн хөгжих болно"³³ гэсэн баримтлал болно. Кимирсенизм бол марксизм- ленинизмээс ялгаатай түүхэн эрин цагийг төлөөлж байгаа үзэл санаа боловч ажилчин ангийн хувьсгалт үйл хэрэгт үйлчилч буй ангийн эрмэлзэл ба үүргийн талаар нийтлэг учир марксизм-ленинизмтэй гүн холбоотой юм. Марксизм- ленинизмээс үзэл санаа-онолын ололтыг амьдралд хэрэгжүүлэх болон хамгаалах үйл явцад кимирсенизм үүсч хөгжсөн түүхтэй гэж үздэг байна.

Энэ бүхнээс үзвэл, Жүчэгийн гүн ухааны үзэл санаа нь өөртөө марксизм- ленинизмын тугийн дор өрнөсөн хувьсгалт тэмцлийн явцад шинэ үзэл санаа болон төрж, идеализм ба метафизикийн аливаа урсгалыг эсэргүүцэж, материалист ба диалектикч байр суурийг хатуу хамгаалж ирсэн үзэл санаа юм.

"Жүчэ" гүн ухаанаас бидний хувьд анхаарч үзүүштэй дараах баримтлалууд байна. Үүнд:

- Үндэсний үзэл сэтгэлгээг хүүхэд наснаас нь төлөвшүүлж хүмүүжүүлэх,
- Эх оронч үзлийг бий болгох үүднээс танин мэдэхүйн сурталчилгааг системтэй явуулах,
- Гадаад хүчин зүйлийг хэт шүтэх бус, улс орон өөрийн хүчинд тулгуурлан, бие даан хөгжих сэтгэлгээг ард түмний сэтгэл зүйд бий болгох,
- Дан ганц машин техникийг шүтэх бус, хүнийг дээдлэх тухай асуудлыг төрийн бодлогын төвд тавьж, энэ талаар тодорхой арга хэмжээг авч, бодитойгоор хэрэгжүүлэх зэрэг болно.

Эцэст нь дүгнэн хэлбэл, Жүчэ гүн ухааны гол ойлголт бол "би", "эзэн" хэмээх ойлголт бөгөөд энэ нь "би" буюу хувь хүний цаана эх орон, үндэстэн, ард түмний эрх ашиг байдаг гэдгийг илэрхийлдэг. Уг гүн ухаанд хүний тухай асуудлыг нийгэм ялангуяа оюун санаа ухамсарын үүднээс авч үзэн, улс орон, үндэстэн ард түмний хувь заяаг нээх үндсэн нэгж бол ард түмэн гэж үзсэн. Энэ гүн ухааны үндсэн зарчим нь онол бол практикт тулгуурлаж, түүнд үйлчлэх ёстой гэсэн зарчим юм. "Жүчэ" гүн ухааны үндсэн агуулгад дараах зүйлс хамаарна. Үүнд: - Хүн бүхнийг шийднэ. Хүн бол бүхний тулгуур мөн. Хүнийг өөрчлөх талаар судалдаг философи юм.

- Хүн өөрийн хувь заяагаа өөрөө шийдэх ёстой. Хүн бүр бие даах, бүтээх чадвартай, бас ухамсартай. Бүтээн байгуулалтын гол эзэн бол ард түмэн гэж үздэг. Иймд ард түмнийг тэнгэр шиг үзэх ёстой.

³³ Ким Чен Ир. Жүчэгийн гүн ухаан бол хувьсгалын өвөрмөц гүн ухаан мөн. УБ., 2005, 10 дахь тал

- Хүн бүр эх орон, улс үндэстнээ хайрлах нь чухал. Учир нь улс орон үндэстнээс холдвол хувь хүн өөрийн хувь заяаг шийдэж чадахгүй.
- Улс орондоо хэрэгтэй ашигтай зүйлийг хүн бүр хэрэгжүүлэх.
- Улс төр, эдийн засаг, төрийн удирдлагыг боловсронгуй болгох эдгээр болно. Өөрөөр хэлбэл, “жүчэ” гүн ухаан нь хүн, нийгэм, төрийг удирдах тухай асуудлыг агуулдаг үзэл юм.

Ашигласан ном материал

- Б.Даш-Ёндон. Чуче – ийн онолын тайлбараас – “Философи, эрхийн судлал”. XXIII боть. УБ., 2008
- Ким Чен Ир. Об идеях Чучхе. Корея. Пхеньян. 1986
- Ким Чен Ир. Жүчэгийн гүн ухаан бол хувьсгалын өвөрмөц гүн ухаан мөн.УБ., 2005
- БНАСАУ-д болсон “Жүчэ” философийн семинар. Пхеньян. 2007.